



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/006/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Пийк Ом Аудит” ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас: 99862066 Цахим хаяг: peakomauditllc@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ОРХОНТУУЛ СУМЫН РАШААНТ
ТОСГОНЫ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Н.БҮРЭНЦОГТ ТАНАА

2026.02.25 № СЭА-2026/006/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/228 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 33,512.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 34 зорилтын хүрээнд 84 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	143,485,360.58	95,956,187.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		67,021,775.57	27,080,376.39
31211	Төрийн сангийн харилцах		67,021,775.57	27,080,376.39
33	АВЛАГА	5	1,864,392.01	1,984,433.21
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		50,000.00	170,041.20
	Бусад авлага		1,814,392.01	1,814,392.01
35	БАРАА МАТЕРИАЛ	6	74,599,193.00	66,891,377.90
3542	Аж ахуйн материал		61,922,246.06	58,394,572.06
3546	Хүнсний материал		1,953,000.00	4,134,500.00
3547	Бусад хангамжийн материал		269,440.00	269,440.00
3548	Бичиг хэргийн материал		10,342,386.94	4,092,865.84
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		928,102,005.85	932,597,376.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	928,102,005.85	932,597,376.45
392	Биет хөрөнгө		866,129,605.85	870,624,976.45
39201	Барилга, байгууламж, орон сууц		904,329,874.00	973,436,070.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		-178,950,400.93	-211,738,301.39
39203	Авто-тээврийн хэрэгсэл		16,000,000.00	16,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		-15,485,775.64	-16000000
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		148,783,960.50	142,053,754.95
39206	Хуримтлагдсан элэгдэл		-68,790,149.59	-91,909,795.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		77,788,354.89	82,488,354.89
39208	Хуримтлагдсан элэгдэл		-36,787,467.65	-48,849,935.29
39214	Бусад үндсэн хөрөнгө		7,506,217.64	7,506,217.64
39217	Ном		11,734,992.63	17,638,611.15
393	Биет бус хөрөнгө		61,972,400.00	61,972,400.00
39301	Програм хангамж		1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-1,500,000.00	-1,500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		61,972,400.00	61,972,400.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		928,102,005.85	932,597,376.45
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,071,587,366.43	1,028,553,563.95
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	16,281,000.00	3,298,540.00
413	Өглөг		16,281,000.00	3,298,540.00
4136	Бусад өглөг			3,298,540.00

51	Засгийн газрын хувь оролцоо		1,055,306,366.43	1,025,255,023.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		275,443,955.60	275,443,955.60
51101	Өмч: - төрийн		213,471,555.60	213,471,555.60
512	Хуримтлагдсан үр дүн		6,334,206.22	-23,717,136.26
5121	Өмнөх үеийн үр дүн		6,334,206.22	6,334,206.22
5122	Тайлант үеийн үр дүн			-30,051,342.48
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		773,528,204.61	773,528,204.61
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,055,306,366.43	1,025,255,023.95
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,071,587,366.43	1,028,553,563.95

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,323,910,499.94	1,610,774,819.77
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,188,843,200.00	1,463,201,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,188,843,200.00	1,463,201,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		135,067,299.94	147,573,519.77
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		135,067,299.94	147,573,519.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		43,897,138.50	82,368,533.42
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			2,000,490.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		40,382,608.40	79,999,814.52
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		2,729,430.10	368,228.90
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	1,367,807,638.44	1,693,143,353.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,369,994,655.89	1,723,194,695.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,308,812,915.89	1,651,433,638.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		934,692,898.00	1,209,958,654.48
210101	Үндсэн цалин		605,815,382.00	692,299,834.43
210102	Нэмэгдэл		298,244,216.00	409,981,445.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт			29,865,000.00
210104	Урамшуулал		30,633,300.00	77,812,374.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		115,408,839.51	149,114,871.01
210201	Тэтгэврийн даатгал		78,771,018.88	102,257,116.89
210202	Тэтгэмжийн даатгал		9,434,581.87	11,980,760.10
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,654,809.23	5,862,518.89
210204	Ажилгүйдлийн даатгал		4,502,636.43	5,746,889.11
210205	Эрүүл мэндийн даатгал		18,045,793.10	23,267,586.02

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		135,067,299.94	146,133,519.77
210301	Гэрэл, цахилгаан		7,384,299.94	9,755,419.77
210302	Түлш, халаалт		122,879,440.00	131,276,920.00
210303	Цэвэр, бохир ус		4,803,560.00	5,101,180.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал			1,440,000.00
210604	Урсгал засвар			1,440,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		13,536,107.84	14,856,871.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		785,100.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		12,751,007.84	14,856,871.49
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		110,107,770.60	129,929,721.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		33,791,921.00	40,784,961.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		9,469,464.50	9,940,317.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		66,845,885.10	79,204,443.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		61,181,740.00	71,761,057.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		61,181,740.00	71,761,057.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		39,547,640.00	49,978,257.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		21,634,100.00	21,782,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	1,369,994,655.89	1,723,194,695.67
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		-2,187,017.45	-30,051,342.48
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		-2,187,017.45	-30,051,342.48

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,324,695,599.94	1,612,775,309.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	785,100.00	2,000,490.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	785,100.00	2,000,490.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	785,100.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,000,490.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,323,910,499.94	1,610,774,819.77
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,188,843,200.00	1,463,201,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	135,067,299.94	147,573,519.77
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,067,299.94	147,573,519.77
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,316,585,930.79	1,649,016,708.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,316,585,930.79	1,649,016,708.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,258,248,030.79	1,575,074,151.95

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	934,692,898.00	1,209,958,654.48
210101	Үндсэн цалин	605,815,382.00	692,299,834.43
210102	Нэмэгдэл	298,244,216.00	409,981,445.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт		29,865,000.00
210104	Урамшуулал	30,633,300.00	77,812,374.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,408,839.51	149,234,912.21
210201	Тэтгэврийн даатгал	78,771,018.88	102,257,116.89
210202	Тэтгэмжийн даатгал	9,434,581.87	11,980,760.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,654,809.23	5,982,560.09
210204	Ажилгүйдлийн даатгал	4,502,636.43	5,746,889.11
210205	Эрүүл мэндийн даатгал	18,045,793.10	23,267,586.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,067,299.94	146,133,519.77
210301	Гэрэл, цахилгаан	7,384,299.94	9,755,419.77
210302	Түлш, халаалт	122,879,440.00	131,276,920.00
210303	Цэвэр, бохир ус	4,803,560.00	5,101,180.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	1,440,000.00
210604	Урсгал засвар	0.00	1,440,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,536,107.84	14,856,871.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	785,100.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,751,007.84	14,856,871.49
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,542,885.50	53,450,194.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,072,921.00	46,808,417.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,469,964.50	6,641,777.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,337,900.00	73,942,557.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,337,900.00	73,942,557.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,703,800.00	52,159,757.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,634,100.00	21,782,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,109,669.15	-36,241,399.18
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,608,620.00	3,700,000.00
	Дотоод эх үүсвэрээр	3,608,620.00	3,700,000.00
222001	Тоног төхөөрөмж	2,233,000.00	
223001	Бусад хөрөнгө	1,375,620.00	3,700,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,608,620.00	-3,700,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,501,049.15	-39,941,399.18
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		67,021,775.57
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		27,080,376.39

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	6,334,206.22	1,055,306,366.43
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			-30,051,342.48	-30,051,342.48
18				
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	-23,717,136.26	1,025,255,023.95

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,697,829,800.00	1,652,716,708.95	45,113,091.05	97.3
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,534,013,300.00	1,503,142,699.18	30,870,600.82	98.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,534,013,300.00	1,503,142,699.18	30,870,600.82	98.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	163,816,500.00	147,573,519.77	16,242,980.23	90.1
132001	Орон нутгийн төсвөөс	163,816,500.00	147,573,519.77	16,242,980.23	90.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		2,000,490.00	-2,000,490.00	#DIV/0!
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,000,490.00	-2,000,490.00	#DIV/0!
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,697,829,800.00	1,652,716,708.95	45,113,091.05	97.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,697,829,800.00	1,652,716,708.95	45,113,091.05	97.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,619,580,100.00	1,578,774,151.95	40,805,948.05	97.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,222,522,100.00	1,209,958,654.48	12,563,445.52	99.0
210101	Үндсэн цалин	732,140,100.00	692,299,834.43	39,840,265.57	94.6
210102	Нэмэгдэл	418,991,200.00	409,981,445.07	9,009,754.93	97.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт		0.00	-29,865,000.00	#DIV/0!
210104	Урамшуулал	71,390,800.00	77,812,374.98	-6,421,574.98	109.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,815,200.00	149,234,912.21	3,580,287.79	97.7
210201	Тэтгэврийн даатгал	103,914,400.00	102,257,116.89	1,657,283.11	98.4
210202	Тэтгэмжийн даатгал	12,225,200.00	11,980,760.10	244,439.90	98.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,112,600.00	5,982,560.09	130,039.91	97.9
210204	Ажилгүйдлийн даатгал	6,112,600.00	5,746,889.11	365,710.89	94.0
210205	Эрүүл мэндийн даатгал	24,450,400.00	23,267,586.02	1,182,813.98	95.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,316,500.00	146,133,519.77	16,182,980.23	90.0
210301	Гэрэл, цахилгаан	14,053,700.00	9,755,419.77	4,298,280.23	69.4
210302	Түлш, халаалт	140,376,800.00	131,276,920.00	9,099,880.00	93.5
210303	Цэвэр, бохир ус	7,886,000.00	5,101,180.00	2,784,820.00	64.7

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,440,000.00	60,000.00	96.0
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,440,000.00	60,000.00	96.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,145,500.00	14,856,871.49	4,288,628.51	77.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,145,500.00	14,856,871.49	4,288,628.51	77.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,280,800.00	57,150,194.00	4,130,606.00	93.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,476,900.00	50,508,417.00	3,968,483.00	92.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,803,900.00	6,641,777.00	162,123.00	97.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,249,700.00	73,942,557.00	4,307,143.00	94.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,249,700.00	73,942,557.00	4,307,143.00	94.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	56,466,900.00	52,159,757.00	4,307,143.00	92.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,782,800.00	21,782,800.00	0.00	100.0
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,697,829,800.00	1,652,716,708.95	45,113,091.05	97.3
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		67,021,775.57	-67,021,775.57	#DIV/0!
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		27,080,376.39	-27,080,376.39	#DIV/0!
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38	38	0.00	100.0
6	Удирдах ажилтан	2	2	0.00	100.0
7	Гүйцэтгэх ажилтан	21	21	0.00	100.0
8	Үйлчлэх ажилтан	14	14	0.00	100.0
9	Гэрээт ажилтан	1	1	0.00	100.0

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 38,938.8 мянган төгрөгийн 3 алдаа илэрч зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар материаллаг алдаа илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой

1.1 Илрүүлэлт: Бичиг хэргийн материалын дансанд 4,092.3 мянган төгрөгийн ном сурах бичиг, аж ахуйн материалын дансанд 32,562.0 мянган төгрөгийн интернэт төхөөрөмжийг бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.4 -д “*Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ*”, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь “*Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Ангилал*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг зөв ангилан, бүртгэж 2026 оны эхний хагас жилд багтаан залруулах;

2. Бараа материалын зарцуулалттай холбоотой

2.1 Илрүүлэлт: Тайлант онд 450.0 мянган төгрөгийн бараа материалыг бөөн дүнгээр нь зарлагдаж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Бараа материалын хөдлөл өөрчлөлтийг холбогдох стандарт, заавар, журмын дагуу үнэн зөв бүртгэж, бүртгэл тайланд тусгаж байх

3. Авлагатай холбоотой

3.1 Илрүүлэлт: Он дамжсан, эзэн холбогдогч нь тодорхойгүй 1,834.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах ажил зохион байгуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Дээрх авлагыг барагдуулах ажил зохион байгуулж, холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх;

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалыг зөв ангилан бүртгээгүй.	1	36,654.3					1	36,654.3				

Бараа материалыг бөөн дүнгээр нь зарлагдсан.	1	450.0					1	450.0				
Он дамжсан авлагыг барагдуулах ажил зохион байгуулаагүй.	1	1,834.5					1	1,834.5				
Дүн		38,938.8						38,938.8				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			